

«ХӨХ ТУГ»-ИЙН ТУХАЙ ХЭДЭН ҮГ

Н.Ариунзаяа*

* Сэтгүүл зүйн магистр

Түлхүүр үг: сонордуулга, гүнээ мэргэн, зан суртал, гэгээрүүлэн боловсруулах, сэтгүүлийн хоршоо, холбон найруулах, дармаллан гаргах, үг шүүмжлэлийн товчоо.

Өнгөрсөн зууны гучаад оны эхээр Дорнод хятадад Манж Го улсыг байгуулсны дараа буюу Энх эрдэмтийн 8 дугаар оны 1 дүгээр сарын зургааны өдрөөс эхлэн хэсэгхэн хугацаанд гарч байсан «Хөх туг» хэмээх сонины нэлээд дугаар Японы монголч эрдэмтэн Футаки Хироши-д хадгалагдан үлдсэний зах зухаас цухас харсанаа өгүүлье. Сониныг Манж Го улсын монгол бичгийн найруулан орчуулах хүрэнээс эрхлэн 7 хоног тутам гаргаж байжээ. Сонины толгойн хэсэгт «Дармаллан явуулах газар: Шинэ нийслэл Юн чан лу 124-р, "Хөх туг"-ийн хоршоо. Дармал явуулах хүн: Куфуно Танаку» гэсэн хаяг буй. Явцын дундаас буюу 5 дахь дугаараас эхлэн Бадрах дэрмаллан явуулагч болсон байна.

Тус сонинд нийтэлсэн «Сая дармал гаргаснаа хэлэх үг» гэсэн гарчигтай сонордуулгад сонины зорилго чиглэлийг тодорхойлж бичихдээ «Муж улсын засгийн газар монгол угсаатны зан суртал дээш сайжрах ба утга соёлын дэлгэрэхийг бодох бээр зорилт болгож, Монгол ардын амьдралыг сайжруулах хурал ба Монгол ардын амьдралыг хөгжүүлэх хуралтай хамтаар сая Хи ху сиян хэмээх Хөх тугийн хоршоо гэрийг байгуулав. Мөн сая Хи ху сиян болбол эдүгээ шмнэ сэтгүүл «Хөх туг»-ийн тэргүүн хуудсыг дармаллан гаргана. Монгол хүмүүний дотор монгол үсэг утгадаа гүнээ мэргэн хийгээд гүехэн мэргэн, бас огт мэдэхгүй хүмүүн ч байна.

«Хөх туг» болбол монгол үсэг утгадаа туйлын гүехэн хүмүүн нарт хүртэл ч үзүүлье гэж санаж байна. Тийн бодохуйд ухаан мэдэл өндөр хүмүүн ба ниббон үсэг, хятад үсгийн шинэ сонсголын бичгийг үзэж байх хүмүүн нарт болбаас энэ «Хөх туг»-ийн ухааны хэмжээ хүрэлцэхгүй газар

үлэмж байна гэж санан хянаваас тэр учирт болбол монгол газарт оршиж байх олон нийтийн дөхмийн тул тэсвэрлэхгүйгээр болохгүй гэж санана.

Энэ «Хөх туг» болбол угсаатны амьдралын дотор хамт амьдран амьдрахын хамтаар хүмүүжиж явъя гэж байх нь мөн юм. Монгол угсаатны зан суртал дээш сайж-

рах хийгээд утга соёлын дэлгэрэхийг хүсэгч хүмүүн нарыг монгол угсаатан хийгээд монгол угсаатны сайжрахыг эргэлзэх хүмүүн нарын нэр алдрын тул энэ «Хөх туг»-ийг түргэнээ хүмүүжүүлэн сайжруулж өгөөт гэж хүснэ. Сая

Хи ху сиян болбол үнэнийг хэлбэл хүмүүн ба бодисын зүйлээр тэгшрээгүй болохуй дор мөн «Хөх туг»-ийн хүмүүжин сайжрахууд нэн гүнээ сэтгэл талбихыг хүсч байна. «Хөх туг» болбол монгол угсаатны хамтаар мандуулан дэлгэрье хэмээх хүслийг өвөрлөж, эдүгээгээс эхлэн гарч ирсэн нь мөн юмаа» гэжээ. Үүнээс үзэхэд монгол угсаатныг гэгээрүүлэн боловсруулах явдал тус сонины үндсэн зорилго байсан нь хэрэгдэж байна.

Шинэ сонин гаргаж эхэлсэнд олон хүн талархаж бичиг, цахилгаан ирүүлснийг сонин эхний хэдэн дугаартаа

хэсэглэн нийтэлсэн байна. Тухайлбал Манж төмөр замын ерөнхий шийтгэгч Одмөрөнгийн ирүүлсэн цахилгаан утсыг «Манж төмөр замын ерөнхий шийтгэгчээс бэлэглэн ирүүлсэн цахилгаан ину: "Хөх туг" сэтгүүлийн хоршоог байгуулахууд чин хэмээн бэлэглэн нийлүүлэх санааг илтгэж, эгнэгт хөгжин

бадрахыг залбирч буй» гэж гол утгыг нийтэлсэн бол, улсын туслах хурлын хэрэг шийтгэгч даргын ирүүлсэн «Бэлэглэх цахилгаан»-нд «"Хөх туг" сэтгүүлийг байгуулсныг бэлэглэж дэвшин дэлгэрэхийг сүсэлмуй» гэжээ. Мөн Азийг ман-

«
Шинэ сонин гаргаж эхэлсэнд олон хүн талархаж бичиг, цахилгаан ирүүлснийг сонин эхний хэдэн дугаартаа хэсэглэн нийтэлсэн байна. Тухайлбал Азийг мандуулах хүрээний монгол хязгаарын холбон найруулах газрын даргаас ирүүлсэн "Хөх туг" сэтгүүлийг дармаллан гаргахыг бэлэглэж, хожмын дэвшин сайжрахыг залбирмуй» гэсэн үгтэй цахилгааныг нийтэлжээ.

»

дуулах хүрээний монгол хязгаарын холбон найруулах газрын даргаас ирүүлсэн «"Хөх туг" сэтгүүлийг дармаллан гаргахыг бэлэглэж, хожмын дэвшин сайжрахыг залбирмуй» гэсэн үгтэй цахилгааныг нийтэлжээ.

Тус сониныг гаргаж эхэлсэнтэй холбогдуулан хэвлэл мэдээллийн бусад байгууллагаас ч талархлын бичиг, захидал ирүүлсэн байна. Түүний дотороос Манжийн солонгос утгын өдөр бүрийн сэтгүүлийн газрыг хамаарагч тушаалтан Ли шин цай-гийн захидал шинэ сонины ач холбогдлыг үнэлж дүгнэсэн байдлаараа онцлог юм.

Тэрбээр захидалдаа «Манж улсын, улсын бодлогыг олон угсаатан улсын ардад сайтар шимтэн нэвтрүүлэхүйн тул олон ард угсаатан ану нэгэнт хялбар ухаарах бөгөөд янаг сэтгэлгээгээр унших олон ард угсаатны хэлэх үгээр хэлбээс шинэ сэтгүүлийн чухал нь юунаас ч илүү чухал тустай учир хэмээн ерийн үесээс бодолхийлэн байсныг болхи миний бие энэ удаа Монгол ард угсаатны заан удирдах үг шүүмжлэлийн товчоо орон болох "Хөх туг"-ийн сэтгүүлийг байгуулсанд ихэд гүнээ утгат учир хэмээн сэтгэлийн угаас баярлан бэлэглэх санааг илтгэмүй. Хэдүй тийм боловч "Хөх туг"-ийн сэтгүүл болбаас гагцхүү улсын бодлогыг тунхаглан уламжилж, энэ удирдах төдийгөөр түүний үүргийг төгсгөн чадвар (чадна — Н.А.) хэмээн бодохгүй, монгол ард угсаатны утга соёлыг уламжлан нийтлэхийг цаасан дээр илэрхийлэн гаргасаар түүний учрыг сайтар илэрхийлж, засгийн эрхийг баригчид хянаж үзэх учрыг мөн шүүмжлэхгүйгээр үл болмой хэмээн санаму. Энэ учраар "Хөх туг"-ийн сэтгүүлийн үүрэг болбаас хүнд бөгөөд их тул заан удирдах хороонд байгч олон авгай нар ихэд чармайн хүчлэх учрыг эрмэлзмүй за» гэж зөвхөн Манж Го улсыг байгуулсныг уламжлан тунхаглах төдий биш, түүх соёлоо сэргээн мандуулж, ард олны мэдлэг ухааныг нээгдүүлэхэд сонин чухал үүрэг гүйцэтгэх ёстойг сануулсан байна.

«Хөх туг» сониныхон өөрийн хэвлэлийг уншигчидтай нягт холбож, тэдний итгэлийг олж авахыг эрмэлзэж байсны нэг гэрч нь «Сэтгүүлийг үзэгч олон авгай нарын хүчин туслахыг хүсэх нь» гэсэн гарчигтай редакцийн өгүүлэл мөн. Уг өгүүлэлд «Гурван оны урд хугацааны дотор дармаллан явуулах байсан монгол шинэ сэтгүүлийг бас мөн дугаараас эхлэн "Хөх туг" хэмээн нэрийг холтгон үзэгч олон авгай нар лугаа улам нөхөр найрыг шинэ зангидахаар болсон амой. Гагц тэмдэглэл учир хүрэлцэхгүй дээр хүмүүн бас үл хүрэлцэх учирт санасан ёсоор явуулан эс чадсан боловч монгол шинэ сэтгүүлийн хамаатай оролдогч бүх тушаалтан нар нэгэн амиар итгэн чармайж, юу боловч үзэгч олон авгай нарын санаанд хүргэмүй хэмээн оролдсоор ирсэн буй. Одоо үзэгч олон авгай нар ч онцгой хөгжүүлэн чармайгаж өгөх нь бүгдээр хэдий зөвдөхгүй боловч баярлах нь эх бичгийг онцгой үлэмж эргүүлсэн учирт буй.

Тэдгээр бичиг алиа боловч цөм монголоо хайрлаж, монголоо хөхүүлсэн нь буюу. Одоо монгол хурлын устан тархаад монгол шинэ сэтгүүлийг "Хөх туг" хэмээн нэрийг халутгасан ану бас ч шинэ сэтгүүлийн мэдүс юмыг үйлдэж, үзэгч олон авгай нарын санаанд хүргүүлсүгэй хэмээх учирт болой. Бидний "Хөх туг" хэмээх хоршооны хүмүүс нар одоох байдлаас нэн үлэмж зүтгэн

чармайж оролдохоор санаж баймуй. Үзэгч олон аагай нар ч нэн ялангуяа тэтгэн тусалж, эх бичиг илгээх учрыг их л эрмэлзэж байна. "Хөх туг" сэтгүүлийг зохиогч газрын бүгдээр ёсолбай» гэжээ. Энд бас сонин хэвлэлийн түшиг тулгуур болсон идэвхтэн бичигчдэд хандаж санаа бодлоо бичиж ирүүлэхийг хүссэн санаа ч тодорхой харагдаж байна.

«Хөх туг» сонин хийц хэлбэр сайтайгаараа тухайн үеийн монгол сонинуудаас ялгарч байжээ. Сонинд фото, зураасан, шог зураг арвин нийтлэхийн зэрэгцээ тусгаарлах шугам, материалыг гоёмсог хийгээд олон янзаар хэрэглэсэн байдаг. Ялангуяа сонины толгойн хэсгийг зэв барьж, амандаа туг зуун нисч яваа хүчирхэг далавчит шувууны зургаар чимэглэсэн нь хараа булаахуйц бөгөөд сонины нэртэй утга дүйхүйц болжээ. Ач холбогдол бүхий чухал уриа, сонордуулга, зарыг онцлон үзэж хятад, монгол үсгээр хадмаллан нийтэлдэг байв. Тухайлбал «Тэнгэр сүрт, газар удаан манай Монгол үүрд тэнгэртэй газартай бат хамтдан бадруултугай. Шинэ жилийн шинэ өдөр. Лувсансэнгэ» гэсэн зүйлийг ингэж нийтэлсэн байна. Мөн «Эзэн хаан Ниффоныг сурвалжилсан нь» гэсэн бичлэгийн гарчгийг гурван давхар хээтэй хүрээнд хийж, мөрдөс бүхий дүрэмт хувцастай эзэн хааны зургийг тавьж, бичлэгийг хас

тэмдэг, нарны цацраг зэргээр чимсэн бол, «Сая дармал гаргаснаа хэлэх үг» гэсэн сонордуулгыг мөн хүрээнд хийж, үүлэн хээ, урт хөлт өрөвтас шувууны гоёмсог зургаар чимэглэсэн байна. Цахилгаан мэдээ, захидал, сэтгэгдэл, зарлалын гарчгийг долгиотой, долгиогүй хүрээнд хийдэг уламжлалтай байжээ.

Тус сонин хийц, зохиомж сайтай фото зургуудыг эхнийхээ нүүрэнд том хэмжээгээр тавьдаг байсны нэг нь анхны дугаарт нийтэлсэн «Монголын цэнгэлт орон» гэдэг нэртэй зураг юм. Уг зурагт хээрийн задгай бэлчээрт хонин сүргээ хариулж яваа малчин хүнийг ур чадвар сайтай дүрсэлсэн байна.

Мөн сонинд нийтэлсэн «Хөх тугийн дуулал» гэдэг шүлэглэлт нийтлэл нэн сонин юм. Түүнд:

1. Хөх тугаа мандуулан
Хүчин сүрээ бадруулж
Хүчирхэг гадаад дайсныг
Хүчлэн чармайж арилгая
2. Цагаан тугаа мандуулан
Цааз ёсыг залруулж
Цэгц муу дайсныг
Чанагш хол зайлуулъя
3. Хар тугаа мандуулан
Хамаг сүрээ бадруулж
Хар хүрээн дайсныг
Хамтаар чармайн устгая
4. Шар тугаа мандуулан
Шударгуу журмаа хүчитгэж
Шаламгайлан урагш зүтгэж

Шинэ Манж улсаа бадруульа хэмээн бичсэн байна. Энэ бичлэгт сонины зорилго агуулагдахын зэрэгцээ, өөрийн сонины сүлд дуутай болохыг эрмэлзсэн санаа байгааг ч анзаарахгүй байх аргагүй санагдана.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Бүрээчин Дархан*. 2002. Дундад улсын сонин сэтгүүлийн түүхэн тойм. Хөххот.
2. 1999. Монголын соёлын түүх. Дэд боть. УБ.
3. 1995. Монголын уран зохиолын дээжис. I боть. УБ.
4. *Норовсүрэн Л.* 1999. Монголын сэтгүүл зүйн өмнөх үзэгдлүүд. УБ.

5. *Норовсүрэн Л.* 2000. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Тэргүүн боть. УБ.

6. «Хөх туг» сонин. Энх эрдэмтийн 8 дугаар оны нэгдүгээр сарын 6, 13-ны болон 4 дүгээр сарын 3, 28-ны дугаарууд.

7. *Окладников А. П.* 1972. Центрально-Азиатский очаг первобытного искусства. Новосибирск.

8. *Фридрих И.* 1979. История письма. М.

Resume

Some words about "Khukh tug"

I expressed about "Khukh tug" ("Blue flag") news, which had been promoted after the Japanese conquered Manjuur and founded a state of Manchu Go or in the beginning of 1930s. In this article, I analyzed mainly publication policy, general political tendency and design features of the "Khukh tug".